

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2024/05/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хэнтий аймаг
Чингис хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Цахим хуудас: www.open.audit.mn
Утас: 70562112
Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390
Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkhegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.03.25 № 392
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.ТӨГӨЛДӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 658,074.2 мянган төгрөг, авлага 285,015.5 мянган төгрөг, бараа материал 133,415.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 937,790.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 2,014,295.2 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 333,168.1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 730,426.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,322,413.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 235,780.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 3,175.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,136.3 мянган төгрөгийг зарцуулж, 39.4 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

232420484

Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5,812.7 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,024,097.8	1,076,505.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	620,606.1	658,074.2
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	283,065.3	285,015.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	120,426.4	133,415.2
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		876,306.2	937,790.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	876,306.2	937,790.2
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		810,493.2	873,518.4
39300	Биет бус хөрөнгө	13	65,813.0	64,271.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,900,404.0	2,014,295.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		15,216.4	1,501.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	15,216.4	1,501.6
41300	Өглөг	17а, 17б	13,243.5	368.1
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,972.9	1,133.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,885,187.6	2,012,793.6
51	Засгийн газрын хувь оролцоо		1,885,187.6	2,012,793.6
51100	Засгийн газрын оруулсан капитал		392,590.9	392,590.9
51200	Хуримтлагдсан үр дүн		1,392,454.5	1,520,060.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		100,142.2	100,142.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,900,404.0	2,014,295.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,665,408.0	3,073,109.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		645,618.2	714,061.0
110	Орлогын албан татвар		248,650.0	382,887.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		248,650.0	382,887.2
113	Хөрөнгийн албан татвар		65,062.1	51,729.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		331,906.0	279,444.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	343,948.2	266,554.0
120	Нийтлэг татварын бус орлого		343,948.2	266,554.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,675,841.7	2,092,494.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,191,485.7	2,788,898.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,191,485.7	2,788,898.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		966,504.6	1,229,289.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		307,811.4	407,210.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		37,035.5	50,446.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		261,697.1	45,864.3
2104	Хангамж, бараа материалын зардал		40,606.2	52,189.7
2105	Нормативт зардал		264.5	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		42,366.9	16,850.8
2107	Томилолт, зочны зардал		8,900.0	17,426.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		71,678.2	386,172.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		196,144.8	253,129.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,224,981.1	1,559,608.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		473,922.3	284,211.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		31,662.8	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,696,111.6	155,141.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-4,190,526.4	129,070.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,438,276.5	2,872,367.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	645,618.2	714,061.0
110	Орлогын албан татвар	248,650.0	382,887.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	248,650.0	382,887.2
113	Хөрөнгийн албан татвар	65,062.1	51,729.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	331,906.0	279,444.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,807.8	4,990.6
1181	Газрын төлбөр	34,098.5	83,109.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	289,999.6	191,344.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,816.7	65,812.2
120	Нийтлэг татварын бус орлого	116,816.7	65,812.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,675,841.7	2,092,494.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,090,527.9	2,606,811.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,090,527.9	2,606,811.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,254.5	1,047,206.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,052.5	405,187.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,618.4	51,775.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,201.1	45,864.3
2104	Хангамж, бараа материалын зардал	39,046.6	39,903.4
2105	Нормативт зардал	0.0	339.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,556.6	12,634.5
2107	Томилолт, зочны зардал	8,900.0	17,426.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,283.6	422,483.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,595.6	51,593.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,258,273.4	1,559,604.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	347,748.6	265,556.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	272,838.6	228,088.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	272,838.6	228,088.2
2200	Дотоод эх үүсвэрээр	272,838.6	228,088.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-272,838.6	-228,088.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,910.0	37,468.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	545,696.1	620,606.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	620,606.1	658,074.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,240,094.3	0.0	6,240,094.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-164,137.6	0.0	-164,137.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,075,956.8	0.0	6,075,956.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-242.7	0.0	-242.7
9	Тайлант үеийн үр дүн	-4,190,526.4	0.0	-4,190,526.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,885,187.6	0.0	1,885,187.6
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,885,187.6	0.0	1,885,187.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,464.0	0.0	-1,464.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,883,723.6	0.0	1,883,723.6
19	Тайлант үеийн үр дүн	129,070.0	0.0	129,070.0
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,012,793.6	0.0	2,012,793.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,664,522.00	1,232,388.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,032.80	1,062,762.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,294,832.80	1,061,391.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,021.80	395,660.22
210101	Үндсэн цалин	280,557.90	218,636.48
210102	Нэмэгдэл	151,438.30	108,275.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,084.50	3,251.00
210104	Урамшуулал	14,393.00	21,213.95
210105	Гэрээт ажлын хөлс	58,548.10	44,283.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,906.60	49,003.03
210201	Тэтгэврийн даатгал	43,436.90	33,986.96
210202	Тэтгэмжийн даатгал	5,110.20	3,998.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,088.20	3,181.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,022.00	679.13
210205	Эрүүл мэндийн даатгал	10,249.30	7,157.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,138.20	284,510.89
210301	Гэрэл, цахилгаан	46,020.70	34,111.47
210302	Түлш, халаалт	267,881.50	248,588.83
210303	Цэвэр, бохир ус	4,236.00	1,810.60
2104	Хангамж, бараа материалын зардал	33,233.80	31,222.59
210401	Бичиг хэрэг	3,002.20	2,994.00
210402	Тээвэр, шатахуун	23,992.00	23,863.39
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,248.00	2,165.70
210404	Ном, хэвлэл	250.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	582.90	582.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,158.70	1,616.70
2105	Нормативт зардал	2,220.10	339.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,220.10	339.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,660.40	29,392.43
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,160.40	6,100.00
210602	Тавилга	4,000.00	0.00
210604	Урсгал засвар	24,500.00	23,292.43
2107	Томилолт, зочны зардал	19,282.20	17,426.00
210702	Дотоод албан томилолт	19,282.20	17,426.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	272,008.10	220,962.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	218,639.20	169,380.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,058.80	366.80
210803	Даатгалын үйлчилгээ	932.40	381.68
210804	Тээврийн хэрэгслийн татвар	397.80	270.61
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	171.70	166.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	719.40	311.20
210807	Газрын төлбөр	50,088.80	50,085.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,361.60	32,875.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,000.00	29,031.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,361.60	3,843.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,200.00	1,371.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,200.00	1,371.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,200.00	1,371.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	265,115.70	169,625.17
223001	Бусад хөрөнгө	265,115.70	169,625.17
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	99,373.50	0.00

230001	Эргэж төлөгдөх зээл	99,373.50	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,664,522.00	1,295,789.49
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,550,188.90	1,284,588.62
320001	Орон нутгийн төсвөөс	1,352,232.80	1,086,632.52
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	197,956.10	197,956.10
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	114,333.10	11,200.87
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.00	8,189.79
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500.00	3,011.08
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,833.10	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	99,038.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	162,439.68

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,175.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,175.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,136.28
2104	Хангамж, бараа материалын зардал	659.98
210401	Бичиг хэрэг	100.00
210402	Тээвэр, шатахуун	559.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,348.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,348.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,127.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,127.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39.41
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	39.41
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	39.41
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,175.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,175.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,438.19
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	737.50

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1. Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн байгууллага 2, төрийн сангийн 1, тусгай сангийн 2, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийг газар 1, нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Засаг даргын тамгын газарт бие даасан дүгнэлт өгч, ИТХ, Аварга тохижилт ОНӨААТҮГ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 51,406.8 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлснээс 49,123.4 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 2,283.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

Засаг даргын тамгын газар:

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас биотехникийн арга хэмжээ авах ажилд гэрээ байгуулж сумын засаг даргын захирамжаар 8,000.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч тухайн ажлыг хүлээж аваагүй, гэрээнд заасан хугацаанд ажил нь хийгдэж дуусаагүй, урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй
2. Эрсдэлийн сангаас 4,030.0 мянган төгрөгийн өвс авч нөөц бүрдүүлсэн боловч бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй, зардалд хаасан
3. ОНХС-аар хийгдсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 2,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг сумын Засаг даргын захирамжыг үндэслэн ЗДТГ-т үндсэн хөрөнгөөр бүртгэсэн боловч хөрөнгийг нь биетээр хүлээж аваагүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

4. Эрх бүхий байгууллагаас тогтоосон халаалтын улирлын эхлэх, дуусах хугацааг баримтлаагүй 8 сараар гэрээ байгуулж халаалтын төлбөрийг 2,283.4 мянган төгрөгөөр илүү төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Орон нутгийн хөгжлийн сан:

1. ОНХС-ийн шилжүүлэг, орон нутгаас санхүүжих дүнг зөв ангилж бүртгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө хэсэгт 26,880.6 мянган төгрөгийн орлогыг илэрхийлээгүй орхигдуулсан
2. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар гэрээ байгуулж 5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө зарцуулсан боловч 2,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг гүйцэтгэгч байгууллагаас хүлээж аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

5.3 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,812.7 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ-ын санхүүгийн тайланг нэгтгэхдээ орлого, зардлыг илүү илэрхийлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	5,812.7			1	5,812.7	1	5,812.7				
ЗДТГ	3	14,230.0	1	4,030.0	2	10,200.0	3	14,230.0				
ИТХ	0	0										
ОНХС	2	29,080.7			2	29,080.7	2	29,080.7				
ХХС	0	0										
БХС	0	0										
Дүн	6	49,123.4	1	4,030.0	5	45,093.4	6	49,123.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Засаг дарга	0												
ЗДТГ	1	2,283.4	1	2,283.4									
ИТХ	0												
ОНХС	0												
ХХС	0												
БХС	0												
Дүн	1	2,283.4	1	2,283.4	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								